

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 12 сарын 14 өдөр

Дугаар А/39

Арвайхээр сум

Хамгаалах хувцас хэрэгсэл, хүчилтөрөгч
өтгөрүүлэгч хуваарилах тухай


Эрүүл мэндийн сайдын 2023 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн “Тоног төхөөрөмж, хэрэгслийг орлогод авч хуваарилах тухай” А/259 дүгээр тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1.Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг цар тахлын үеийн хариу арга хэмжээ, эрүүл мэндийн тогтолцооны бэлэн байдлын хүрээнд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тусламжаар нийлүүлэгдсэн хамгаалах хувцас хэрэгсэл, хүчилтөрөгч өтгөрүүлэгчийн хуваарилалтыг хавсралтаар баталсугай.

2.Хуваарилагдсан хүчилтөрөгч өтгөрүүлэгч, хамгаалах хувцас хэрэгслийг хөрөнгийн бүртгэлд авч, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-т, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Захиргаа санхүү нийтлэг үйлчилгээний алба (Б.Валя)-д тус тус даалгасугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

